



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/43

Баян-Өндөр сум

Ээлжит бус хуралдаан
зарлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, 46.6 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 07 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 02/11 дүгээр тогтоолоор батлагдсан “Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэг”-ийн 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дэх удаагийн сонгуулийн Ээлжит бус Х хуралдааныг 2026 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр цахим хэлбэрээр зарлан хуралдуулж, дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр бэлтгэл хангасугай. Үүнд:

1. Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;

(Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн жагсаалт батлах тухай 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн №03/34 дүгээр тогтоол)


2. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай;

(Хороодын даргыг батлах тухай 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 03/09 дүгээр тогтоол)

2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит бус Х хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Зөвлөлийн гишүүдэд даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
даргын 2026 оны 04 дүгээр сарын 08-ны
өдрийн А/В дугаар захирамжийн хавсралт

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ БУС Х ХУРАЛДААНЫ БЭЛТГЭЛ ХАНГАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит бус Х хуралдааныг зарласан тухай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдийг мэдээллээр хангах;

IV/08-нд багтаан

Ажлын алба

2.Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай (Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн жагсаалт батлах тухай) асуудлын илтгэл, холбогдох тооцоо, судалгаа, лавлагаа, гарах шийдвэрийн төслийг хавсаргаж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

IV/13, IV/16-ны дотор

Аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр

3.Тогтоолд өөрчлөлт оруулах тухай асуудлаар гарах шийдвэрийн төслийг боловсруулж Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

IV/13, IV/16-ны дотор

Аймгийн ИТХ-ын Эдийн засаг,
үйлдвэрлэлийн хөгжлийн хорооны
гишүүн Б.Оюун-Эрдэнэ
Аймгийн ИТХ-ын Ёс хорооны гишүүн
Г.Эрдэнэбат

4.Хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан холбогдох Хороод ажиллаж санал дүгнэлт гаргах;

IV/15-ны дотор

Холбогдох Хороод

5.Техник зохион байгуулалтын бэлтгэл ажлыг хангах;

IV/16-ны дотор

Аймгийн ИТХ-ын Нарийн бичгийн
дарга Ш.Ганболд

АЖЛЫН АЛБА